

URGENT төслийн хүрээнд боловсруулж буй “Монументал чимэглэл”, “Ландшафтын дизайн” хичээлүүдийн хөтөлбөрт өгөх санал

2022 оны 09 сарын 13

URGENT төслийн хүрээнд ландшафтын архитектурын хөтөлбөрөөс дээрх хичээлүүдийг бакалавр, магистрын хичээлийн хөтөлбөр боловсруулах журмыг баримтлан загварын дагуу шинэчлэн сайжруулсан нь сайн талтай байна. “Ландшафтын дизайн” магистрын мэргэшүүлэх хичээлийн хөтөлбөрийн бичлэг, бүтцийн хувьд цэгцтэй, зохион байгуулалт сайтай боловсруулсан нь сайшаалтай байна.

Энэхүү хичээлүүдийн хөтөлбөр боловсруулалтаас харахад цаашид бичвэрийн ажлыг сайжруулах үүднээс зарим нэгэн зүйлд анхаарал хандуулан засах нь зүйтэй болов уу. Үүнд:

А. “Монументал чимэглэл” хичээлийн хөтөлбөрт

1. Хичээлийн хөтөлбөрийн бичилтэд үг хооронд зай авах, үсгийн фонтыг жигд болгох, үг үсгийн алдааг засварлах,
2. Хичээлийн хөтөлбөрийн эхний нүүр хэсэгт бичигдсэн хичээлийн нэр нь “Хот суурин цэцэрлэгжүүлэлт” гэж бичигдсэн боловч агуулгыг харахад монументал чимэглэлийн хичээл байгааг анхаарч аль зөв эсэх,
3. Хичээлийн залгамж холбоо болон зэрэгцүүлэн үзэхэд тохиромжтой хичээлийн нэр, индекс дутмаг. Тухайлбал: Техник зураг зүй, уран зураг, Өнгө хослол, зохиомж гэх мэт хичээлүүдийг судлан оруулбал,
4. Хичээлийн зорилго, ач холбогдол хэсэгт: “Монументал чимэглэлийн “ажлын бүтээл туурвихад тохирох материалууд, арга техникийг судлах түүн дээр тулгуурлан чимэглэлийн ажил, бүтээл туурвин гүйцэтгэх чадварыг эзэмших ач холбогдолтой” гэж найруулан бичих,
5. Хичээлээр эзэмших мэдлэг,чадвар, дадал хэсэгт бичигдсэн бичиглэлийн найруулгыг засах,
6. Хичээлийн хөтөлбөрийн 3-р хуудас дахь хүснэгтийн эхний баганад “Дүгнэх зүйл” гэж бичсэнийг “ үнэлгээ “ гэж засах,
7. Хичээлийн хөтөлбөрийн 4-р хуудас дахь хичээлд ашиглах ном, сурах бичгийн жагсаалтад мэргэжлийн болон холбогдох материал, эх сурвалжийг нэмэх,
8. Хичээлд ашиглах ном, сурах бичгийн жагсаалтуудаа нэг загварт оруулах,


Б. “Ландшафтын дизайн” хичээлийн хөтөлбөрт

1. Хичээлийн зорилго, ач холбогдол хэсэгт: зорилго дотор нь агуулгаа давхцуулан бичсэнийг эргэж дахин хянах
2. Хичээлийн зорилго, агуулгынхаа бичлэгийн найруулгад анхаарах
3. Хичээлийн хөтөлбөрийн 3-р хуудас дахь хүснэгтийн эхний баганад “Дүгнэх зүйл” гэж бичсэнийг “ үнэлгээ “ гэж засах,

Хичээлийн хөтөлбөр боловсруулагч та бүхний ажлыг дэмжиж, сайжруулах үүднээс зарим нэгэн саналыг өглөө. Та бүхэн маань авах гээхийн ухаанаар хандаарай.

Амжилт хүсэн ерөөе.

ХААИС, Агроэкологийн  
сургуулийн Таримал судлал, Ой,  
Ландшафтын архитектурын

Санал бичсэн:   
Б. Батдэлгэр, доктор. дэд